

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөөгийн шийдэл ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2024/06/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn
Мөрөн сум
2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn
Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа
Утас: 99389208 Цахим хаяг: b_myadagmaa@yahoo.com
Аудитор Ц.Мөнхтуяа
Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsagul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.15 № 01/253
танай _____ -ны № _____ -т

ХӨДӨӨГИЙН ШИЙДЭЛ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.БАТТУЛГА
ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Хөдөөгийн шийдэл ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хөдөөгийн шийдэл ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хөдөөгийн шийдэл ХХК-ийн үндсэн хөрөнгийн дансанд улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн газар тариалан, хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэдийг дэмжиж, тэдэнд түрээсээр худалдан борлуулах зориулалт бүхий 3,201.3 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Аудитын гол асуудал

Хөдөөгийн шийдэл ХХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 541.3 сая төгрөгийн алдаа зөрчлийг илрүүлснээс 507.8 сая төгрөгийн алдааг аудитын хугацаанд залруулж, 33.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

Бусад асуудлын хэсэг

Хөдөөгийн шийдэл ХХК нь тайлант жилд батлагдсан орлогын төлөвлөгөөг 12.2 хувиар давуулж биелүүлсэн ба зардлын гүйцэтгэл 89.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

9724040618

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	33,086,260.90	76,750,820.20
1.1.2	Дансны авлага	-	63,471,570.00
1.1.6	Бараа материал	7,961,480.00	18,104,480.00
1.1.9	Борлуулахаар эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	29,995,000.00	19,475,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	71,042,740.90	177,801,870.20
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,001,406,033.33	2,979,936,533.33
1.2.2	Биет бус хөрөнгө	1,261,000.00	821,000.00
1.2.3	Биологийн хөрөнгө	782,057,700.00	782,057,700.00
1.2.4	Бусад биет бус хөрөнгө		31,047,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,784,724,733.33	3,793,862,233.33
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,855,767,474.23	3,971,664,103.53
2	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	248,749,834.10	-
2.1.1.3	Татварын өр	431,352.35	10,889,575.19
2.1.1.4	НДШ - ийн өглөг	-	578,200.01
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	119,655,000.00	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	368,836,186.45	11,467,775.20
2.2	Өр төлбөрийн нийт дүн	368,836,186.45	11,467,775.20
2.3	Эзэмшигчдийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	391,683,000.00	429,555,000.00
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	3,171,682,200.00	3,171,682,200.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-76,433,912.22	358,959,128.33
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	3,486,931,287.78	3,960,196,328.33
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	3,855,767,474.23	3,971,664,103.53

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар		Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	22,521,000.00	378,305,557.95
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	40,964,000.00
3	Нийт ашиг (алдагдал)	22,521,000.00	337,341,557.95
10	Ерөнхий ба удирдлагын зардал	98,954,912.22	260,576,884.12
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-76,433,912.22	76,764,673.83
19	Орлогын татварын зардал	-	7,676,467.38
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-76,433,912.22	69,088,206.45
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	-76,433,912.22	69,088,206.45
24	Орлогын нийт дүн	-76,433,912.22	69,088,206.45

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)				
ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2022 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-
2023 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	391,683,000.00	3,171,682,200.00	-76,433,912.22	3,486,931,287.78
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	366,304,834.10	366,304,834.10
Залруулсан үлдэгдэл	391,683,000.00	3,171,682,200.00	289,870,921.88	3,853,236,121.88
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	69,088,206.45	69,088,206.45
Өмчид гарсан өөрчлөлт	37,872,000.00	-	-	37,872,000.00
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	429,555,000.00	3,171,682,200.00	358,959,128.33	3,960,196,328.33

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)			
Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	153,560,534.10	297,135,757.95
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	134,480,534.10	289,829,800.00
	Бусад мөнгөн орлого	19,080,000.00	7,305,957.95
1.2	Мөнгөн зарлага (-)	112,754,273.20	253,320,198.65
	Ажиллагчдад төлсөн	42,702,512.09	95,349,260.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	10,875,345.10	24,283,076.58
	Бараа материал худалдан авахад төлсөн	48,577,908.02	85,229,595.29
	Ашиглалтын зардалд төлсөн	1,035,389.58	15,983,179.57
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	7,500,000.00	26,007,365.00
	Бусад мөнгөн зарлага	-	75,694.51
	Татварын байгууллагад төлсөн	2,063,118.41	6,064,652.70
	Даатгалын төлбөрт төлсөн	-	327,375.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	40,806,260.90	43,815,559.30
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	7,720,000.00	-
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	6,400,000.00	-
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,320,000.00	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(7,720,000.00)	-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	33,086,260.90	43,815,559.30
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	33,086,260.90
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	33,086,260.90	76,750,820.20

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Өмнөх оны үзүүлэлт	2023 он			
				Зорилтот түвшин	Гүйцэтгэл	Өөрчлөлт	Биелэлт
1	Нийт орлого	сая. төг	22.5	337.1	378.3	-41.2	112.2
	Хөрөнгийн эргэн төлөлтийн орлого	сая. төг	2.0	300.8	281.6	19.2	93.6
	Хүнсний ногооны үрний орлого	сая. төг			49.2	-49.2	0.0
2	Нийт үйл ажиллагааны орлого	сая. төг	20.5	36.3	47.5	-11.2	130.9
	Хүнсний ногооны тракторын үйлчилгээний орлого	сая. төг	1.5	13.2	18.6	-5.4	141.2
	Ногоон тэжээлийн орлого	сая. төг		7.5	8.1	-0.6	108.0
	Хадлангийн тракторын түрээсийн орлого	сая. төг		15.6	13.5	2.1	86.5
	Бусад орлого	сая. төг	19.1	0.0	7.3	-7.3	0.0
3	Нийт үйл ажиллагааны зардал	сая. төг	99.0	337.3	301.5	35.8	89.4
	Нийт цалингийн сан	сая. төг	30.4	103.4	77.6	25.8	75.0
	ТУЗ-ийн цалингийн зардал	сая. төг	15.2	25.2	24.8	0.4	98.2
	ТУЗ бичиг хэргийн зардал	сая. төг	0.0	2.4	2.1	0.3	87.5
	НД-ын шимтгэл	сая. төг	4.5	28.0	18.2	9.7	65.2
	Хүнсний ногооны тракторын шатахууны зардал	сая. төг	0.0	7.2	6.2	1.0	86.1
	Ногоон тэжээл тариалах шатахууны зардал	сая. төг	0.0	3.4	3.4	0.0	100.0
	Хадлангийн тракторын шатахууны зардал	сая. төг	0.0	9.6	9.0	0.6	93.7
	Бичиг хэрэг, оффисын зардал	сая. төг	3.5	4.8	4.3	0.5	89.8
	Интернет, утасны зардал	сая. төг	0.4	2.4	2.3	0.1	96.8
	Оффисын түрээс	сая. төг	2.7	6.0	4.5	1.5	75.0
	Дулааны зардал	сая. төг	1.0	6.0	2.0	4.0	0.0
	Цахилгааны зардал	сая. төг	0.1	6.0	16.0	-10.0	266.4
	Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	сая. төг	1.0	1.8	1.6	0.2	88.9
	Шатахууны зардал	сая. төг	7.5	12.0	11.6	0.4	96.8
	Томилолтын зардал	сая. төг	3.9	18.0	6.0	12.0	33.4
	Засвар үйлчилгээний зардал	сая. төг	1.6	4.8	4.8	0.0	100.0
	Аудитын Төлбөр	сая. төг	2.5	3.0	3.0	0.0	100.0
	Газрын төлбөр	сая. төг		1.0	0.5	0.5	49.7
	Тээврийн хэрэгслийн оношилгоо	сая. төг		0.1	0.1	0.0	100.0
	Тээврийн хэрэгслийн татвар	сая. төг		0.1	0.1	0.0	100.0
	Даатгалын үйлчилгээ	сая. төг		0.2	0.3	-0.2	207.2
	НББ-ийн бодлогын баримт бичиг	сая. төг		3.0	3.0	0.0	100.0
	Шагнал урамшуулалын зардал	сая. төг		2.0		2.0	0.0
	Хөдөлмөр хамгааллын зардал	сая. төг	0.3	2.4	2.3	0.1	96.9
	Сургалтын зардал	сая. төг	2.0	3.0	2.8	0.2	93.3
	Зар сурталчилгааны зардал	сая. төг	2.0	2.0	1.8	0.2	90.0
	Агуулахын түрээс	сая. төг		7.2	6.0	1.2	83.3
	Бусад үйл ажиллагааны зардал	сая. төг				0.0	0.0
	Тээврийн зардал	сая. төг		3.0	3.0	0.0	100.0
	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	сая. төг			41.0	-41.0	0.0
	Элэгдэлийн зардал	сая. төг	20.4	69.4	43.3	26.1	62.4
4	Татварын өмнөх ашиг/ алдагдал	сая. төг	-76.4	-0.2	76.8	-77.0	
	Татварын зардал	сая. төг	0.0	0.0	7.7	-7.7	
5	Татварын дараах ашиг	сая. төг	-76.4	-0.2	69.1	-69.3	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 507.8 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

- Төмс, саримсны 30.0 сая төгрөгийн үр биетээр оршин байхгүй, иргэдэд гэрээний үндсэн дээр олгосон үр борлуулах зориулалттай эргэлтийн бус хөрөнгө дансанд бүртгэлтэй, авлага үүсгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх;" 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" заалттай нийцэхгүй, "оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул залруулж, борлуулах зориулалттай эргэлтийн бус хөрөнгө дансны үлдэгдлийг бууруулж, авлагаар бүртгэсэн.
- Борлуулах зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгөнд 228.8 сая төгрөгийн элэгдэл байгуулсан нь "Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл ажиллагаа" СТОУС 5-р стандартын 25-р параграф "Аж ахуйн нэгж борлуулах зорилгоор эзэмшиж буй гэж ангилсан эсвэл борлуулах зорилгоор эзэмшиж буй гэж ангилсан данснаас хасах бүлгийн нэг хэсэг байх эргэлтийн бус хөрөнгийг элэгдүүлэхгүй(эсвэл хорогдуулахгүй)", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэж заасантай нийцэхгүй, "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул байгуулсан элэгдлийг буцааж залруулсан.
- Өмнөх онд хүлэмж түрээсээр авсан иргэдийн эргэн төлөлтөөс харилцах дансанд орж ирсэн 119.6 сая төгрөгийг орлогоор бүртгээгүй, урьдчилж орсон орлогоор тайлагнаж, тайлант онд орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх;" 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;" заалттай нийцэхгүй, "тасалбар болголт" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул тайлант үеийн орлогыг бууруулах залруулсан.
- Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор ОНӨГ-аас 72.9 сая төгрөгийн 59 толгой үхсэн малыг Хөдөөгийн шийдэл ХХК-д шилжүүлсэн тогтоол гаргасны дагуу биетээр оршин байхгүй хөрөнгийг орлогоор бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх;" 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалттай нийцэхгүй, "оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул биологийн хөрөнгө данснаас бүртгэлд тусгасан үхсэн малыг хасч залруулсан.
- Аймгийн ИТХ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/92 дугаар захирамжаар тус компанид Шинэмөрөн худалдааны төв ХХК-аас 2023 онд шилжиж ирсэн хуучин toyota prius-20 маркийн автомашиныг орлогод авахдаа анхны өртөг 12.6 сая төгрөгөөр орлогод авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх;" заалттай нийцэхгүй, "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул элэгдлийн дүн 5.8 сая төгрөгөөр бууруулж залруулсан.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Компанийн ажиллагсдад томилолтоор ажиллах хугацаанд 0.4 сая төгрөгийн хоолны мөнгийг давхардуулан олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байх бөгөөд аудитын явцад давхардуулж олгосон хоолны мөнгийг Хөдөөгийн шийдэл ХХК-ийн компанийн харилцах дансанд тушааж, байгууллагыг хохиролгүй болгосон.
- Аж ахуйн үйл ажиллагаанд зарцуулсан, ашиглалтад тавьж олгосон, хашаа барихад зарцуулсан банз, хаалга зэрэг 16.5 сая төгрөгийн материалыг зарлагадаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" заалттай нийцэхгүй, "оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул бараа материалын үлдэгдлийг бууруулж, хашааг орлогод авч залруулсан.
- Өмнөх онд малчинтай байгуулсан гэрээгээ цуцалсан байхад цалин олгохоор өр төлбөр үүсгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул 2.7 сая төгрөгөөр өр төлбөрийг бууруулж залруулсан.
- Хөвсгөл аймгийн Засаг даргын 2022 оны А/474 дүгээр захирамжаар тус байгууллагад эзэмшүүлсэн 10,349 кв.м газрыг үнэлж бүртгэлд тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:", "14.4.5.бүх орлого;" гэсэн заалттай нийцэхгүй, "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад 31.0 сая төгрөгийн залруулга хийж, газар эзэмших эрхийг бүртгэлд тусгасан.

Аудитаар нийт 33.5 сая төгрөгийн зөрчил² илрүүлснээс санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн 33.5 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмжийг өгсөн.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Техник, тоног төхөөрөмжийн эргэн төлөлтийн авлагыг барагдуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Иргэдэд түрээслэн өмчлүүлэх гэрээгээр олгосон техник, тоног төхөөрөмжийн эргэн төлөлтийн авлагыг барагдуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар бэлтгэгдэж тус компанийн эзэмшилд шилжиж ирсэн хөрөнгүүдийг ангилж бүртгэх, борлуулалтын орлого, борлуулсан бүтээгдэхүүний өртгийг хүлээн зөвшөөрөх, түүнтэй холбоотой авлага, өглөг үүсгэх зэрэг нягтлан бодох бүртгэлийн бодлогууд тодорхой биш байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;" заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт дээрх асуудлыг тодорхой тусгасан өөрчлөлт оруулах

3. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд ТУЗ-ийн аудитын хороо, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон гүйцэтгэх удирдлагын зүгээс дотоод хяналтыг зохион байгуулж, хэрэгжүүлээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно." заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Компанийн дүрэмд заасан дотоод хяналттай холбоотой заалтыг хэрэгжүүлж ажиллах.

4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 20.3, 20.4 заалтад заасан ТУЗ-ийн хараат бус гишүүн, гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулалттай холбоотой мэдээлэл, гүйцэтгэх захирлын гэрээ, ажлын гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт, гэрээний биелэлтийг хэлэлцсэн хурлын тэмдэглэл, гэрээг сунгах эсэх шийдвэр, тухайн жилд төлсөн бүх төрлийн албан татвар, төлбөр, хураамж, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн мэдээллийг ил тод, цахим хуудсаар мэдээлээгүй.

Өгсөн зөвлөмж:

Хууль, журамд заасан мэдээллүүдийг ил тод, цахим хуудсаар мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 33.5 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 28.2 сая төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Биетээр оршин байхгүй хөрөнгө бүртгэлтэй байна.	4	119,458.5			4	119,458.5	4	119,458.5		
Балансаас балансанд шилжиж ирсэн автомашиныг анхны өртгөөр нь орлогод авсан	1	5,775.0			1	5,775.0	1	5,775.0		
Малчинтай байгуулсан гэрээг цуцалсан байхад цалингийн өглөг үүсгэсэн	1	2,683.5			1	2,683.5	1	2,683.5		
Өмнөх онд орлогоор хүлээн зөвшөөрөх ёстой байсан орлогыг урьдчилж орсон орлогоор бүртгэж, тайлант оны орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн	1	119,655.0			1	119,655.0	1	119,655.0		
Борлуулах зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгөнд элэгдэл байгуулсан	1	228,846.9			1	228,846.9	1	228,846.9		
Байгууллагын газар эзэмших эрхийг бүртгээгүй	1	31,047.0	1	31,047.0			1	31,047.0		
Томилолтоор ажиллах хугацаанд хоолны мөнгийг давхардуулан олгосон	1	355.3			1	355.3	1	355.3		
Дүн	10	507,821.2	1	31,047.0	9	476,774.2	10	507,821.2		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Гэрээний хугацаа дууссан авлагыг барагдуулаагүй	1	33,476.6					1	33,476.6
Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд тодорхой бус байгаагаас бүртгэлтэй холбоотой алдаа гарч байна.	1	-					1	-
Дотоод хяналт хангалтгүй	1	-					1	-
Дүн	3	33,476.6					3	33,476.6

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төрийн хэмнэлтийн хуулийн 20-р зүйлд заасан мэдээллийг ил тод, цахимаар мэдээлээгүй.	1	-					1	-
Дүн	1	-					1	-

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ОНӨҮГ	1	1			1			
	НИЙТ								